

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 21-ний өдөр

№24/02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Өндөрхаан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх заалт, 2024 оны 08 сарын 21-ний өдрийн 24/02 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Компанийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралтаар баталсугай.
- Компанийн дүрмийг хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажилд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Хуулийн зөвлөхд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.АШХҮҮ

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 21-ний өдөр

№24/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Өндөрхаан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.1 дахь заалт, 2024 оны 08 сарын 21-ний өдрийн 24/02 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгож чөлөөлсүгэй. Үүнд:

Ердийн гишүүд:

- Г.Цогбадрах
- Г.Сэлэнгэ
- Ч.Хандсүрэн
- Г.Уянга
- Ө.Ашхүү
- С.Дэлгэржаргал

Хараат бус гишүүд:

- Ц.Батбаяр
- Д.Батбаяр
- Ц.Халиун

- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Мөнхбадралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.АШХҮҮ

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 21-ний өдөр

№24/04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Өндөрхаан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.1 дэх заалт, 2024 оны 08 сарын 21-ний өдрийн 24/02 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ердийн гишүүд:

Ч.Ганхуяг
Н.Эрдэнэтулга
Б.Золбоо
Ц.Тайшир
С.Нямгэрэл
Г.Билгүүн

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Хараат бус гишүүд:

А.Азбаяр
Б.Солонго
О.Одсайхан

- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Мөнхбадралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.АШХҮҮ

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 21-ний өдөр

№24/05

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХООР ШИЙДВЭРЛЭЖ, ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЖ ЭНГИЙН ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.16 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 2024 оны 08 сарын 21-ний өдрийн 24/02 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь ... () төгрөгийн ханшаар тооцон ... () ширхэг энгийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд байгуулсан Санхүүжилтийн гэрээний холбогдох заалтын дагуу 15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөгийн өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлэх асуудлыг түдгэлзүүлсүгэй.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж цаашид шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.АШХҮҮ